



**ЁС ЗҮЙН ХОРОО**  
Засгийн газрын Хүрээ, Самбуугийн гудамж 11,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141  
Утас: 51-266021, Факс: (976-51) 264460  
Цахим шуудан: [info@ec.gov.mn](mailto:info@ec.gov.mn)  
Цахим хуудас: [ec.gov.mn](http://ec.gov.mn)

2026.07.09 № 1/286

танай -ны № -т

Тогтоол, чиглэл хүргүүлэх тухай

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд Ёс зүйн хорооны 2025 оны 09 дүгээр тогтоолоор улсын хэмжээнд анх удаа төрийн байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагыг үнэлэн, үр дүнг хүргүүлсэн билээ. Энэ нь төрийн байгууллага, албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх механизм бий болж, төрийн албанд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, ажлын уялдааг хангах боломжийг бүрдүүлэхэд зохих хувь нэмэр оруулж байна.

Улсын хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, ёс зүй, сахилга хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайллыг сайжруулах, Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг тогтмолжуулах арга хэмжээг бодит үр дүнд чиглүүлэх зорилгоор Ёс зүйн хорооны 2026 оны 03 дугаар тогтоолоор байгууллагын ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг шинэчлэн, аргачлалын хамт баталсныг <https://ec.gov.mn/shiidver> холбоосоор татан авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана уу.

Түүнчлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, олон нийтэд мэдээлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх зэрэг ажлыг эрчимжүүлж, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх үүднээс дараах чиглэлийг хүргүүлж байна. Үүнд:

1. Байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээнд албан хаагчдыг бүрэн хамруулж, эрсдэлд өртөх шалтгаан, хүчин зүйлсийг тодорхойлж, хариу арга хэмжээг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх;

2.Байгууллага, салбар, нэгжид гарсан ёс зүйн зөрчлийн бүртгэлийг сайжруулж, зөрчил давтан гарахаас урьдчилан сэргийлэх, зөрчлийг бууруулах зорилтот арга хэмжээг хэрэгжүүлж, тайлагнах;

3.Гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагааг хууль тогтоомжид заасан хугацаанд бүрэн хийж, дэд хорооны дүгнэлтийг үндэслэж, ёс зүйн хариуцлага ногдуулах, зөрчлийн талаарх мэдээллийг тухай бүр өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулж, мэдээлэх;

4.Албан томилолтоор гадаад, дотоодод ажиллаж буй төрийн албан хаагчдыг хүлээн авах (угтах, үдэх) цайллага хийх, архи согтууруулах ундаа хэрэглэх, мөрийтэй тоглоом (казино) тоглох, энэ төрлийн үйлчилгээний газраар үйлчлүүлэх зэргээр хуулиар хориглосон үйлдэл гаргахгүй байх болон төрийн байгууллагын эд хөрөнгө, албаны машиныг зориулалт бусаар, хувийн хэрэглээнд хэрэглэхгүй байх (Үүнд:Төрийн байгууллага болон Олон Улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн нэгж, ТӨҮГ, ХК хамаарна), түүнд хяналт тавих;

5.Байгууллагын удирдлагын зүгээс эерэг соёлыг төлөвшүүлж, ёс зүйтэй, ил тод, шударга харилцаа, хандлагаар бусдыг үлгэрлэн манлайлж, ёс зүй, сахилга хариуцлагыг эрхэмлэх;

6.Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал болон шаардлагатай зардал, төсвийг шийдвэрлэж, үр дүнд хяналт тавих.

Эдгээр чиглэл болон Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаарх мэдээлэл, зөвлөгөөг байгууллага, салбар, нэгжийн нийт албан хаагч, нийтийн албан тушаалтнуудад түгээж, хэрэгжилтийг зохион байгуулж, хамтран ажиллана уу.

Хүндэтгэсэн,



Ёс зүйн хороо  
Удирдлага  
Ёс зүйн хорооны дарга  
Цэнддаваа Амартөгс  
2026-07-09 18:00:55